



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/3д

Улаанбаатар хот

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2, 40.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд хамгааллын тухай хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллах "Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо"-г шинэчлэн байгуулсугай.

2. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны шинэчилсэн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Хууль, тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа зохион байгуулж шаардлагатай тайлан, санхүүгийн тооцоо судалгааг гаргаж дүүргийн Засаг даргад танилцуулж ажиллахыг Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо (Х.Цогцэцэг)-д үүрэг болгосугай.


4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Дүүргийн Засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/13 дугаар захирамж хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 04 дугаар сарын 06-ны өдрийн 132 дугаар
захирамжийн хавсралт



ХҮҮХДИЙН ЭРХИЙН ХУУЛЬ ЗҮЙН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Хүүхдийн эрхийн хууль зүйн
хорооны дарга:
Гишүүд:

(Засаг даргын орлогч)
(Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын
албаны дарга)
(Багахангай, Налайх дүүргийн Эрүү,
Иргэний хэргийн анхан шатны тойргийн
шүүхийн Тамгын газрын дарга (зөвшилцсөнөөр)
(Налайх, Багахангай дүүргийн
Прокурорын газрын дарга (зөвшилцсөнөөр)
(Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх
ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн
бичгийн дарга)
(Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны
удирдлагын хэлтсийн дарга)
(Боловсролын хэлтсийн дарга)
(Эрүүл мэндийн төвийн дарга)
(Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
хэлтсийн дарга)
(Цагдаагийн хэлтсийн дарга)
(Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн
дарга (зөвшилцсөнөөр)
(Монголын хуульчдын холбооны
гишүүн өмгөөлөгч (зөвшилцсөнөөр)

Нарийн бичиг:
бөгөөд ажлын албаны дарга

(Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын
хэлтсийн дарга)